

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ  
МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААР  
ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХАМТАРСАН  
ХУРАЛДААНААС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Нэг.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт  
оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан  
хуралдаанаас дэмжээгүй санал:**

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах, үүнтэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж хэлэлцүүлэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар**

2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**"1 дүгээр зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.2.1.энэ хуулийн 15.3-т заасан нөхцөл, шаардлага хангасан албан татвар төлөгчийн тухайн улиралд албан татвар суутган төлөгчтэй хийсэн худалдан авалтад төлсөн албан татварын 20 хүртэл хувийг буцаан олгох бөгөөд иргэний дотоодод үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтад төлсөн албан татварыг 100 хүртэл хувийг буцаан олгох. Өргөн хэрэглээний хүнсний барааны жагсаалт, хэрэгжүүлэх хугацаа, тайлагнах журмыг Засгийн газар батална.”

Өргөн хэрэглээний хүнсний барааны жагсаалтад согтууруулах ундаа, тамхи, ресторан, нийтийн хоол, түргэн хоол болон хүргэлтийн үйлчилгээний худалдан авалтыг хамааруулахгүй байхаар журамд тусгана.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай**

**Хоёр.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас дэмжээгүй санал:**

1.Хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

**"1 дүгээр зүйл.**Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн "мэдэгдэл, түүний нэмэлт өөрчлөлтийг" гэснийг "мэдэгдлийг" гэж өөрчилсүгэй."

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар**

2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн "7.5 дахь хэсгийн "түүний нэмэлт, өөрчлөлтийг", "төсвийн тодотголын" гэснийг тус тус хассугай" гэснийг "7.5 дахь хэсгийн "төсөл, төсвийн тодотголын" гэснийг хассугай" гэж, мөн зүйлийн дугаарыг "2" гэж тус тус өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар**

---o0o---